

бодлогын төлөвлөлт, зохицуулалт, тодорхой асуудлаар баримтлах байр суурийг тодорхойлоход голлох үүрэг гүйцэтгэх боллоо.

Өөр нэг шинэ гэмээр хандлага бол монголын дипломат албанд буюу гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд улсын ерөнхийлөгч, УИХ-ын дарга, ерөнхий сайд нарын үүрэг илүү нэмэгдэж тэд олон оронд айлчилж дээд хэмжээний уулзалт хийж хоёр болон олон талт харилцааны тодорхой асуудлыг шийдвэрлэдэг болж байна.

Гадаад харилцааны үйл ажиллагаанд олон нийт, нам, эвслийн зүгээс хяналт тавих явдал мэдэгдэхүйц сайжирч хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр гадаад бодлогын үйл ажиллагааг мэдээлэх, тоймлох, санал дүгнэлтээ сурталчлах нь нэмэгдлээ.

ГХЯ, ДТГ-уудын үйл ажиллагаа судалгаа, мэдээлэл, иргэдийн эрх ашгийг хамгаалах, эдийн засгийн хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх зэрэг салбарт идэвхжиж тодорхой үр дүнтэй ажиллах болсон нь анзаарагдаж байна. Дипломатч нарын бие даан сэтгэх, өөрийн ур, ухааныг уралдуулах, хэлэлцээ ярилцлага хийх чадвар ч өсч байгааг бодит туршлага харуулж эхлэв.

Энэ бүхнээс үзвэл, Монгол Улсын гадаад бодлогын зарчим, чиглэл цоо шинээр тодорхойлогдож, дипломат албанд ч шинэлэг хандлага лавширсаар байна.

МОНГОЛ ДАХЬ ХИЛИЙН БҮСҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ТӨЛӨВ

*Сакура Кожима**

1. Хилийн худалдаа хөгжүүлэх нь далайгаас алслагдсан орны хилийн бүсүүдийн хөгжлийн шинэ стратеги мөн.

Монгол шиг далайгаас алслагдсан орны эдийн засагт гадаад эдийн засгийн харилцааны ач холбогдолыг хэтэрхий өргөх гээгүй билээ. Хил нийлж байгаа орнуудын хооронд бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь далайгаас алслагдсан орон буюу бүсэд их ач холбогдолтой нь магадтай. Азийн ШАҮО буюу АСЕАН-ы орнуудын эдийн засгийн амжилттай хөгжлийн загвар нь далайн чанад дахь зах зээлд хялбар хүрэх эрэг орчмын газарзүйн таатай байршлын нийтлэг шинж юм. Экспортын амжилт нь хөгжиж байгаа үндэстний эдийн засгийн нийт хөгжлийн гол эх үүсвэр мөн бөгөөд газарзүйн байршил шийдвэрлэх урьдчилсан нөхцөл нь болно. Монгол эрдсийн баялаг нөөцтэй боловч өөрийн байршил, хоцрогдонгуй дэд бүтэц зэргээс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байна. Дэд бүтцийн доголдлоос гадна ажиллах хүчин дутагдалтай эдийн засаг нь гадаадын фирмүүдийг урихад үнэхээр ашиггүй байна. Ажиллах хүчээр хомс эдийн засагт ажиллах хүчин амархан шавхагддаг учраас өртгийн зардал аяндаа өсөн гадаадын пүүсүүдийн ашиг аяндаа алдагддаг. Яагаад гэвэл ажиллах хүчний нөөцийн ачаар цалинг доогуур барьж байж болдог байна. Монголд далайгаас алслагдсан байршил (бас хоцронгуй дэд бүтэц)

*Токай Их Сургуулийн эрдэмтэн

1 ШАҮО-шинээр аж үйлдвэржсэн орнууд

ажиллах хүчний сийрэг байдал хоёр нь гадаадын фирмүүдийн өртгийн ачааллыг өсгөж болох урьдчилсан нөхцөл бүрдүүлдэг.

Иймд хүн ам сийрэг, далайгаас алслагдсан оронд хөгжлийн уян хатан стратегийг хайх хэрэгтэй байна. “Эдийн засгийн дэд бүсийг бий болгох нь нэгэн эрчимтэй арга хэмжээ болно. Ялангуяа Монголын хувьд төмөр зам буюу авто замаар дамжин далайд хүрэх явдал зайлшгүй хэрэгтэй байна. Хилийн районуудад эдийн засгийн харилцаа хөгжиж ирэхэд зам тээврийн нөхцөл бүрдэж барилга байгууламж аажмаар баригдаж эхлэх бөгөөд энэ нь далайгаас алслагдсан Монголд их ашигтай болно. Бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны эхний шатанд хилийн худалдаа энэхүү хамтын ажиллагааны гол хэсэг нь болж байдаг. Хилийн бүс дэх өргөн хэрэгцээний барааны худалдаа нь даатгал, санхүүжилт, тээвэр, агуулах, гадаадын шууд хөрөнгө оруулалт зэргийг хөгжүүлэхэд түлхэц болно.

Хятад, оросын хилийн худалдааны үр дүнд хөдөлмөрлөх хүчний экспорт жуулчлал хөгжиж эхэлсэн байна. Тэгээд нутгийн түүхий эдийг боловсруулах, хилийн худалдааны шугамаар тэдгээрийг экспортлох зорилгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт хилийн бүсэд явагддаг бөгөөд энэ үйл ажиллагааг хилийн худалдааны “ГХӨ” гэж тодорхойлдог. Ихэвчлэн Гонконг, Тайваны компаниуд Орос, Хятадын хилийн бүсэд хөрөнгө оруулалтыг идэвхтэй хийж байна. ГХӨ Хэлбэрийн хилийн худалдаа жирийн худалдаанаас өөр бөгөөд хилийн эдийн засгийг хөгжүүлэхэд идэвхтэй дэмжлэг болдог юм. Яагаад гэвэл хөрөнгө, технологи, удирдлагын ноу-хау-г шинээр нэвтрүүлэх бололцоо олгож, ажлын талбарыг бий болгоно. Дээр дурдсан бүх үйл ажиллагаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг зүй ёсоор татах Тээвэр, зочид буудал, жижиглэн худалдааны дэлгүүр зэрэг дэд бүтцийг аажмаар хөгжүүлэхийг дэмжиж байна. Энэ бүх бодит ажиллагаа нь “Зүүн Хойт Азийн эдийн засгийн бүс” шиг бүсийн эдийн засгийн харъяалалыг баталгаажуулж байна. “Өмнөд Хятадын эдийн засгийн бүс”, Тайландын “Бат-ын эдийн засгийн бүс” зэрэг нь хилийн хөрш бүсүүдийн эдийн засгийг бүхэлд нь хөгжүүлэхэд маш үр нөлөөтэй болохыг батласан. Хэрэв хилийн бүсүүдийн хоорондын эдийн засгийн харилцаа цаашид эрч хүчээ авбал одоогийн төлөвлөж байгаа “Зүүн Хойт Азийн эдийн засгийн район” нь монголын цаашдын хөгжилд дэмжлэг болох юм. Энэ асуудалд хандах хандлага алхам алхмаар хийгдэх ёстой боловч далайгаас алслагдсан бүсүүдийн хооронд хилийн худалдааг эрчимжүүлэн хөгжүүлэх нь зайлшгүй чухал юм.

2. Монголын эргэн тойрны нутгуудын хилийн худалдааны одоогийн байдал.

Зүүн Хойт Азид Хятад-Оросын ялангуяа Хармөрөн муж, Сибирийн алс дорнодын хооронд хилийн худалдаа, нийт өртөг болон худалдсан барааны төрлөөр ихээхэн хөгжиж байна. Харин Монгол тус бүсийн Хилийн худалдаанд харьцангуй өчүүхэн хувийг эзэлсээр байна. Монголын гол түнш нь БНХАУ-ын Өвөр Монгол болно. Бидэнд Хятад-Оросын хилийн худалдаатай холбоотой бодит байдал, тоо баримт хэрэгтэй байна. Энэ нь Монголын урт хугацааны хөгжилд дэм түлхэц болно.

(1). 1990-ээд оны Хятадын бүсийн хөгжлийн шинэ стратеги

1990-ээд оны Хятадын Стратегийн зорилго нь далайн эрэг хавийн эрчимтэй хөгжиж буй бүс болон хязгаар нутгийн хөгжлийн хол зөрүүг

багасгахад чиглэж байна. Төв засгийн газар хилийн алслагдсан эдийн засгийг гол хөгжүүлэгч нь хилийн худалдаа гэж албан ёсоор үзэж зарим гол хотуудыг “чөлөөт бүсийн хот” болгон хөнгөлөлт үзүүлж байна. 1992 оныг хүртэлх хугацаанд худалдааны нэгдүгээр зэргийн 21 цэгийг нээсэн байна. Хятад-Оросын харилцаа муудахаас өмнө хилийн бүсүүдэд хил хоорондын бага хэмжээний худалдаа байжээ. Энэ худалдаа нь хоёр орны улс төрийн харилцаа муудаж хилийн худалдаа бүрмөсөн хаагдсан 1969 он хүртэл үргэлжилж байсан уламжлалтай юм. Хүйтэн дайн эцэслэж, Хятад-Оросын харилцаа хэвийн болоход хилийн худалдаа сэргэж, аажмаар хөгжсөн юм. Саяхан нутгийн захиргаа, нийтийн худалдааны корпораци, гадаадын болон хувийн компаниуд хилийн худалдаанд чухалчлан оролцож эхэлсэн бөгөөд энэхүү уламжлалт худалдаанд ард түмэн, хил орчмын оршин суугчид гол үүрэг гүйцэтгэж байна. Машин, тоног төхөөрөмжийг оруулагчид гүйцэд боловсруулсан бараа гаргаж төлбөрөө хийхийг зөвшөөрсөн “тэнцүү бартерийн (бараа солилцооны худалдаа гэж тодорхойлогддог барааны солилцооны шинэ хэлбэр төрж бий болсон юм. Бараа солилцоо социалист гэгдэж байсан орнуудад шийдвэрлэх гол хэлбэр болж байна. Гэвч Хятад 1991 оноос эхлэн хуучин дорнод европын түншүүдтэйгээ хатуу валютаар төлбөр хийж эхэлсэн юм. Ингээд уламжлалт хилийн худалдаа бодит шаардлагын дагуу шинэчлэгдэж эхлэв.

(2). Хятад-Оросын хилийн худалдааны хөгжилт.

1983 онд Хилийн худалдаа сэргэсний дараа, Хятад-Оросын худалдаа ялангуяа 1988 онд төв засгийн газрууд хилийн худалдааны ажиллагаанд нэгдсэн удирдлагыг халж орон нутгийн захиргаа, хувийн компаниудад эрх олгохоор шийдсэний дараа эрч хүчээ авав. 1992 онд нийт худалдааны хэмжээ 2120 сая Швейцари франкад хүрчээ. Сибирийн алс дорнодын бүсийн хилийн худалдааны бараг 90% нь Хятадаас орж ирсэн юм. Хилийн худалдаа хурдан өсөлттэй байвч цаашдын хөгжилд удаашралтай байдал ажиглагдаж байна. Хоёр болон олон талын хандивлагчдын зүгээс туслах туслалцаа дэд бүтцэд дутагдалтай байна. Жишээ нь Амар мөрөнд гүүр тавих шаардлага байна. Хоёрдугаарт, экспортын зөвшөөрлийн систем зарим хэвээр үйлчилсээр байгаа нь гүйлгээтэй барааны төрөл зүйлийг өргөн хамарч чадахгүй байна. Иймд цаашид энэ салбарт илүү чөлөөт байдал бий болгох, гуравдугаарт экспортын барааны хяналтыг чангатгах шаардлагатай байна.

(3). Монгол Хятадын хоорондын хилийн худалдаа

Монголын худалдааны гол түнш нь Өвөр Монгол мөн бөгөөд түүний худалдааны хамгийн том төв нь Эрээн, Хятад-Оросын худалдааны том төв нь Манжуур болно. Өвөр Монголын хилийн худалдааны ерөнхий хэмжээ 1988 онд бараг 96 сая америк доллар хүрч байсан бол 1991 онд 257 сая америк доллар хүрч өсчээ. Бусад мужуудтай харьцуулахад их хурдан өсөлттэй байна. Гэвч Өвөр Монголын хилийн худалдааны 80 гаруй хувь нь Оросын алс дорнодын бүсэд чиглэгдэж байна. 1991 онд Монголтой хийсэн худалдаа 10-аас доош хувьтай байна. Ийм байдлаар Монголын хилийн худалдаа зүүн хойт Азийн бүсэд харьцангуй бага хувийг эзэлсээр байна. Гэвч Монголын эдийн засгийн хувьд энэ нь хэзээ ч ач холбогдолоо алдахгүй. Өвөр Монголын Засгийн газар 1992 оноос эхлэн бүрэн

нээлттэй бодлого хэрэгжүүлж, 13 том, жижиг хотыг “чөлөөт бүс” болгон төмөр замын буюу “нөөцийг хөгжүүлэх бүс”-ийн дагуу “технологийн чөлөөт бүс” байгуулжээ. Энэ нь хилийн худалдааг чөлөөтэй болгож, удирдах захиргааны байгууллагуудад зохих эрх олгох боломж олгов. 210000 м² талбайг эзэлсэн “хятад-Оросын хилийн худалдааны шинэ бүсийг байгуулахаар төлөвлөж байна.

Манжуур нь Өвөр Монгол дахь бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны гол газар болж байна. “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”, “Эрчим хүч хөгжүүлэх бүс”, “Экспортын чиглэлтэй хөдөө аж ахуй, мал аж ахуйн холбогдолтой үйлдвэрийн хөгжлийн бүс” гэх мэтчилэн эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулж эхэлсэн юм. Эдгээрийн дотор 57 км² талбайг эзэлсэн “хилийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-д боловсруулах үйлдвэр, тээврийн төхөөрөмжүүд, батлагаатай агуулах байгуулахаар төлөвлөжээ. Одоо тэнд Япон, Хятад, Гонконгийн хамтарсан үйлдвэрүүд гадаадын зах зээлд зориулж эрэгтэй хүний цамц гэх мэтийг үйлдвэрлэн гаргаж байна. Монгол, Хятадын хоорондын худалдааны хувьд гэвэл хоёр тал Эрээн, Замын-Үүдэд Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг бэхжүүлж, зорчигчдийн хөдөлгөөнд зориулсан зам нээжээ. Мөн хамтарсан шалгалтын байр, өртөө, зочид буудлыг барьж өргөтгөл хийв. Монгол, Өвөр Монголын хоорондын хамтын ажиллагааны энэхүү чиглэлийг үнэхээр дэмжих хэрэгтэй байна.

3. Зүүн Хойт Азийн эдийн засгийн бүс байгуулах болон Монголын эдийн засаг

Орос, Хятадын хоорондын хилийн худалдааны хөгжил нь Япон, Өмнөд Солонгос, Хойт Солонгос, Сибирийн Алс дорнод, Хятад, Монголыг хамарсан “Зүүн Хойт Азийн эдийн засгийн бүс” байгуулахад түлхэц болно. Хилийн худалдаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, жуулчлал, янз бүрийн үйлчилгээ, үйлдвэрлэл гэх мэтийн эдийн засгийн солилцооны бусад хэлбэрүүдийг хөхүүлэн дэмжинэ. Бас зам тээврийг хөгжүүлнэ. Монгол шиг далайгаас алслагдсан жижиг орны хувьд хилийн бүс байгуулах нь авто зам, төмөр зам байгуулах, голын тээвэр хэрэглэх замаар их ашиг олж болно. Бүсийн хамтын ажиллагаагүйгээр Монгол далайд хүрэх тээвэр байгуулж чадахгүй. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санаачлагаар төлөвлөгдсөн “Түмэн голын сав” төслийг төлөвлөн хэрэгжүүлэх боллоо. Дэд бүтцийн салбар дахь Хятад-Оросын зарим хамтарсан төсөл амжилттай хэрэгжиж байна. Хэрэв тэдгээр төсөл дэд бүтцийн хөгжил төдийгүй дотоодын эдийн засгийн хөгжлийн бүтэцтэй холбогдсон бол Монголын хэтийн хөгжилд их түлхэц болохсон билээ.

4. ДҮГНЭЛТ

Энд би Монголыг тойрсон нутагт бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцлийг тодруулах гэсэн юм. Хөрш орнуудын бүсийн хамтын ажиллагааны ач холбогдолыг дахин онцлон тэмдэглээд, бид дараахь зүйлээр цаашдын судалгаа хийж, мэдээлэл солилцох хэрэгтэй байна гэж үзэж байна.

Үүнд:

1. Бүс нутгийн хөдөлмөрийн хувиараас олох үлэмж ашгийг, өөрөөр хэлбэл бүс нутгийн доторх үйлдвэрлэлийн элементүүдийн харилцан

нөхсөн байдлаас олох тэр ашгийг авч үзэж, оролцогч бүс нутаг (орон) бүр өөрийн нөөц боломжийг бүрэн ашиглах, хөгжүүлэх талаар үлэмж хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

Зарим нь эрдсийн баялаг нөөц буюу ховор металтай байхад нөгөө хэсэг нь сайн мэдлэгтэй ажилчидтай байж болно. Хөрш орнууд хамтын үйл ажиллагаа буюу хамтарсан судалгааг идэвхтэй хөгжүүлэх, бололцоо байвал, бусад орон буюу байгууллагууд ч тусалж дэмжих хэрэгтэй байна. Өөрсдийн хамтын хүчин чармайлтаар бусад хөгжилтэй орнуудаас илүү дэвшилтэт технологи, хөрөнгө оруулалтыг татаж чадна.

2. Эрхийг төвлөрүүлэлгүй орон нутгийн захиргаад болон бүр хувийн компаниудад олгох явдал бүсийн эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд үр ашигтай болох нь батлагдсан юм. Хилийн бүс дэх худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулах журамд улсаас оролцох оролцоог багасгах, хөнгөн шуурхай болгох явдал шаардлагатай. Нөгөө талаас орох цэг буюу гаальд татварын байгууллагын хүчин чадлыг бэхжүүлэх нь дэд бүтцэд цаашид хөрөнгө оруулах сангийн эх үүсвэр болно.

3. Дэд бүтцэд хөрөнгө оруулах хүчин чармайлтад улсын оролцоог багасгах, удирдлагын бие даасан ажиллагаа, давуу байдлыг ашиглахад цаашдын алхмыг хийх хэрэгтэй байна. Үүнээс гадна энэ салбарт олон улсын тусламжийн хамтын ажиллагаа нэн шаардлагатай байна.